

ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ /МАЯГТ 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа		2025 оны 1 дүгээр сарын 01- ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл		Үнэт цаас гаргагчийн нэр: Хөвсгөл Алтандуулга ХК УБГД: 1710001001 Үнэт цаасны код: ADU Утасны дугаар: 70386030, 98119703
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Хүнс, хөдөө аж ахуй - Үр тарианы гурил үйлдвэрлэл - Үр тариа болон бусад ургамал тариалалт
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		Пантер Мидлан Аудит ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		15,734,200 ширхэг энгийн хувьцаа
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Б.Энхмөрөн /Хүний нөөцийн менежер/ Хянасан: Г.Бат-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	2025 оны хөндлөнгийн хараат бус аудитор хянасан санхүүгийн тайланг хавсаргав. /Хавсралт-1/
	Орлогын тайлан	
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	

	Мөнгөн гүйлгээний тайлан	
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	2025 оны хөндлөнгийн хараат бус аудитор хянасан санхүүгийн тайланг хавсаргав. /Хавсралт-1/	



1.2.	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>	
	Пантер Мидлан Аудит ХХК нь Аудитын олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хараат бусаар Хөвсгөл Алтандуулга ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөвлөнгийн аудитын үйлчилгээг хийж гүйцэтгэсэн гэдгийг “Хөвсгөл Алтандуулга ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн. “ /Хавсралт-1/	
2.	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>	
2.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Нийт ашгийн хувь 1.77% Цэвэр ашгийн хувь 0.14% Нийт хөрөнгийн өгөөж 0.09% Өөрийн хөрөнгийн өгөөж 0.26%
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Эргэлтийн харьцаа 0.64 Түргэн хөрвөх чадварын харьцаа 39.1%
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Гадаад хүчин зүйлс: 2025 онд МУ-ын эдийн засаг 4,9 хувиар өссөн ба ХАА-н салбарын агшилт энэхүү өсөлтийг 3.6 нэгж хувиар бууруулсан тоон үзүүлэлт гарсан. Хүнс үйлдэрлэл нь МУ-н тэргүүлэх салбар тул ЗГ-аас хэрэгжүүлж буй бодлого маш их нөлөө үзүүлдэг. Ялангуяа импортын гурилын татварыг 0-сэн нь энэ салбарын өсөлтийг хязгаарлан зах зээлээ алдахад хүргэсэн ба уналтанд оруулсанаар жижиг гурилын үйлдвэрүүд эхнээсээ үйл ажиллагаа нь зогсож байна. Дотоод хүчин зүйлс: Гурил үйлдвэрлэлийн салбарын уналтаас үүдэн үйлдвэрүүдийн зах зээл дэх үнийн бодлого алдагдаж үнэ буурсанаар ашигт ажиллагаанд нөлөөлсөн, нөгөө талаас байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ган гачиг нүүрлэснээр газар тариалангийн салбар чанаргүй ургац авсанаар түүхийн эдийн хомсдол, түүхийн эдийн үнийн өсөлт зэрэг хүчин зүйлс нь өртөгийг нэмэгдүүлсэн.
2.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	Байхгүй.
2.5.	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	Тайлант хугацаанд ямар нэгэн зээлийн үйлчилгээ аваагүй ба 2021-2022 онуудад Төрийн банкнаас авсан зээлийн үйлдэгдэл өнөөдрийн байдлаар хугацаа хэтэрсэн байдалтай байна.

ЭН АН
ОГЕ
ДУ
20
377

3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/
----	--

	Тайлан хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.																																
4.	Цалин урамшууллын мэдээлэл																																
	Компани цалин урамшуулал нь үндсэн цалин болон ажлын гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллаас бүрддэг ба 2025 онд ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирлын цалин тогтмол байж харин гүйцэтгэх ажилтануудын цалинг 15-40 хүртэлх хувиар ажил мэргэжлийн шатлалтай хамааруулан нэмэгдүүлсэн.																																
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл																																
	Хөвсгөл Алтандуулга ХК-ний ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. 2025 онд 4 удаа хуралдаж, 5 тогтоол гаргажээ. Компанийн бүтэц зохион байгуулалттай холбоотой асуудлаар боловсруулсан баримт бичгийн төсөл, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай холбогдуулж ТУЗ-өөс гаргах дүгнэлт, ажилтан, албан хаагчдын цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудлууд, удирдах албан тушаалтны томилгооны асуудлаар ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хорооны гишүүдэд урьдчилан танилцуулж, тэдний саналыг авч ажилласан болно. Магадлан итгэмжлэсэн лабораторид бүрэн шинжилгээ хийх шинжилгээний аппарат, боловсруулах үйлдвэрт 1кг савлагааны тоног төхөөрөмж суурилуулж, бүтээгдэхүүний савлагааг өргөжүүлэн ашиглалтад бүрэн оруулсан нь газар тариалан, боловсруулах үйлдвэрийн шат дамжлага бүрт чанар, стандартыг мөрдөх, хянах, зэрэгцүүлсэн дүгнэлт хийх зэрэг олон талын ач холбогдолтой чухал хөрөнгө оруулалт болж чадсан байна. Хаврын тариалалт, түүний бэлтгэл ажил, тариалалтын явц, намрын ургац хураалтын ажилтай ТУЗ—ийн дарга болон зарим гишүүд тогтмол танилцан, үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажилласан.																																
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл																																
	Улс орны эдийн засгийн тодорхой бус байдал давамгайлсан бизнесийн орчинд ялангуяа гурилын үйлдвэрийн салбарт гаргасан төрийн буруу шийдвэр гаргалттай холбоотойгоор үүсэх санхүүгийн хүндрэлтэй байдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нөлөөлөх нөлөөлөл, хүлээж болзошгүй алдагдалыг тооцоолж түүхийн эдийн чанарт илүү анхаарч, түүхийн эдийн татан авалтыг тодорхой хязгаартайгаар хийсэнээр бүтээгдэхүүний чанарыг хадгалж зах зээл дээрх нэр хүндийг өсгөж ажилласан.																																
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/																																
	<table><tr><th>№</th><th>Хувьцаа эзэмшигчийн нэр</th><th>Хувьцааны тоо</th><th>Хувь</th></tr><tr><td>1</td><td>Тэстрейд ХХК</td><td>7,997,200</td><td>50.83%</td></tr><tr><td>2</td><td>Ж.Жигжидсүрэн</td><td>1,397,786</td><td>8.88%</td></tr><tr><td>3</td><td>С.Хүрэлбаатар</td><td>1,295,398</td><td>8.23%</td></tr><tr><td>4</td><td>Б.Мандхай</td><td>982,468</td><td>6.24%</td></tr><tr><td>5</td><td>М.Золзаяа</td><td>937,532</td><td>5.96%</td></tr><tr><td>6</td><td>5-аас доош хувьцаа эзэмшигчид</td><td>3,123,816</td><td>19.86%</td></tr><tr><td></td><td>Нийт дүн</td><td>15,734,200</td><td>100%</td></tr></table>	№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь	1	Тэстрейд ХХК	7,997,200	50.83%	2	Ж.Жигжидсүрэн	1,397,786	8.88%	3	С.Хүрэлбаатар	1,295,398	8.23%	4	Б.Мандхай	982,468	6.24%	5	М.Золзаяа	937,532	5.96%	6	5-аас доош хувьцаа эзэмшигчид	3,123,816	19.86%		Нийт дүн	15,734,200	100%
№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Хувь																														
1	Тэстрейд ХХК	7,997,200	50.83%																														
2	Ж.Жигжидсүрэн	1,397,786	8.88%																														
3	С.Хүрэлбаатар	1,295,398	8.23%																														
4	Б.Мандхай	982,468	6.24%																														
5	М.Золзаяа	937,532	5.96%																														
6	5-аас доош хувьцаа эзэмшигчид	3,123,816	19.86%																														
	Нийт дүн	15,734,200	100%																														
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																																

	Компани тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлээгүй болно.
9.	Ногдол ашигийн мэдээлэл
	2025 оны ногдол ашиг хуваарилах талаарх асуудлыг Гүйцэтгэх захирал өргөн барьж, ТУЗ-н хурлаар шийдвэрлэнэ.
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	- Ажилтануудыг идэвхижүүлэх зорилгоор зохион байгуулдаг “Ажилтны нэг өдөр” 5 төрөлт тэмжээн болон байгууллагын нэрэмжит спортын тэмцээнийг сум орон нутаг болон ойролцоо орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийг хамруулсан нь амжилттай болж, жил бүр уламжлалт арга хэмжээ болгон зохион байгуулж байна. - Ахмадын баяр болон сар шинийн баярыг угтан байгууллагаас гавьяныхаа амралтад гарсан ахмад ажилтнууд болон нийт ажилтнууддаа баяр хүгэж хүндэтгэл үзүүлсэн. - Сумын иргэдийн дунд зохион байгуулж буй аливаа ажилд хандивлагчаар оролцохын зэрэгцээ жил бүр эх үрсийн баяраар зорилтод бүлгийн сурагчидад бэлэг гардуулж байна.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр: Гүрлхаажав Бат-Эрдэнэ

Албан тушаал: “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн

гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Батмөнх Энхмөрөн

Албан тушаал: Хүний нөөцийн менежер

Гарын үсэг:

Handwritten signature in red ink.